

ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2019 ОНЫ 8 ДУГААР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2019 оны 08 дугаар сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:

Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд: Тайлант хугацаанд аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдааныг 1 удаа хийж, 4 асуудал хэлэлцсэн.

2019 оны 08 дугаар сарын 29-ний байдлаар Монгол Улсын төрийн дээд одон медалиар шагнуулахаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 78 иргэний тодорхойлолтыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн хурлаар, дээд шатны яам, агентлагийн санал дүгнэлт ирсэн 71 иргэний тодорхойлолтыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох байгууллагуудад уламжилсан.

Аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр 74 иргэн, аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр 111 иргэнийг шагнаж, урамшууллаа.

Аймгийн Засаг даргын 2019 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/80 дугаар захирамжаар батлагдсан “2019 оны нэгдсэн төлөвлөгөө батлах тухай” захирамжийн хэрэгжилтийг аймгийн ЗДТГ-ын бодлогын хэлтсүүд, цэргийн штаб, Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд, харьяа байгууллагуудаас хоёрдугаар улирлын байдлаар нэгтгэн хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний холбогдох хэлтэс, агентлагийн дарга нарт ажил эрчимжүүлэх албан тоот хүргэв. Хэрэгжилтийн товчоог танилцуулбал:

№	Төлөвлөгөөний хавсралтын нэр	Хэрэгжүүлэх арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц								
			Хэрэгжилт						Хойшлогдсон	Гүйцэтгэлийн хувь	Оноо
			Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатанд /50 - 89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9%/					
100%	70%	30%	Хөр	3/б							
1	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө	77	67	4	2		2	2	93,87	4,69	
2	Аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар сонсох асуудлын төлөвлөгөө	8	6		1		1		78,75	3,94	
3	Сургалт, семинар, зөвлөгөөний төлөвлөгөө	55	41	5			9		80,9	4,05	
4	Орон нутагт хийгдэх нээлттэй хаалганы өдөрлөгийн төлөвлөгөө	15	6	4	3		1	1	69,28	3,46	

5	Орон нутаг, харъяа хэлтэс агентлагуудад хийгдэх хяналт-шинжилгээ үнэлгээ шалган туслах ажлын төлөвлөгөө	27	13	7	4			3	79,58	3,98
6	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах төлөвлөгөө	6	4					2	66,67	3,33
Дүн		188	137	20	10			15	84,61	4,23

Аймгийн төр, нутгийн захиргааны болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн шуурхайг 2 удаа зохион байгуулж 11 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажиллалаа.

ЗГ-ын 11-11 төвд өссөн дүнгээр 35 санал хүсэлт, гомдол ирснээс 29 санал хүсэлт, гомдлыг шийдвэрлэн 6 шийдвэрлэх шатандаа байна.

Төрийн албаны стандартын хүрээнд: Аймгийн хэмжээнд байгаа төрийн жинхэнэ албаны сул орон тооны захиалгыг нэгтгэн албан тушаалын тодорхойлолтын төслийн хамт Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.

НҮБ ийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж байгаа “Монгол Улсад мэргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь” төсөл, “МЕРИТ” төсөл, Төрийн албаны зөвлөл хамтран “Төрийн албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах” чиглэлээр зохион байгуулсан арга зүйн сургалтад 2019.08.26-27-ны өдрүүдэд аймгийн 3 төлөөлөл хамрагдав.

ТАЗСЗ-өөс зохион байгуулж буй үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр мэдээллийн самбар, ДУС, facebook болон www.tov.gov.mn цахим хуудасны “ТАЗСЗ” цэсээр олон нийтэд сурталчилан танилцуулж байна. Мэдээ мэдээлэл байршуулсан байдал: /2019.08.29-ний байдлаар тоогоор/

№	Мэдээ мэдээллийн	
	Цэс	Тоо
1	Цаг үеийн мэдээ мэдээлэл	18
2	Тогтоол шийдвэр, Хуралдаан	2
3	Бүрэлдэхүүн	-
4	Нөөцөөс нөхөх зар	1
5	Төрийн албаны мэргэшлийн шалгалтын зар	-
6	Удирдах ажилтны сонгон шалгаруулалтын зар	-
НИЙТ ДҮН		21

2019 оны 08 дугаар сарын 29-ний байдлаар салбар зөвлөлд:

№	Төрөл	Нийт ирсэн	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй
1	Албан бичиг	185	26	25	1
2	Өргөдөл, гомдол	27	27	27	-

Тайлант хугацаанд салбар зөвлөлөөс 40 албан бичиг гадагш явуулсан.

Гадаад харилцаа: БНХАУ-ын Жилинь мужид 2019 оны 08 дугаар сарын 21-24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Хятад-Зүүн хойд Азийн хамтын ажиллагааны анхдугаар дугуй ширээний уулзалт, экспод Төв аймгийн Засаг даргын орлогч Ч.Сарангэрэл, Зуунмод сумын ИТХ-ын төлөөлөгч Х.Цэрэнбат, Н.Дэлгэржаргал нар амжилттай оролцож, эдийн засаг, худалдаа болон аялал жуулчлалын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд хамтран ажиллахаа илэрхийлсэн

байна. Мөн “Харилцан итгэлцсэн хамтын ажиллагааг өргөжүүлж, Зүүн Хойд Азийн гэрэлт ирээдүйг бий болгох” сэдвийн хүрээнд Төв аймаг бусад улсын муж, аймгуудтай эдийн засгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлж, худалдааны төлөөлөгчийн газар нээн ажиллуулах, бизнесийн салбарын түншлэл, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт татах чиглэлд тодорхой төслүүдийг танилцуулсан.

2019 оны 08 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд аймгийн Засаг дарга Ж.Батжаргал, ИТХ-ын төлөөлөгч Б.Ганбат нар БНСУ-ын Пёнтак хотод зочилж, хотын захирагч Жан Чан Сунтай уулзан аймаг, хотын хооронд харилцаа хамтын ажиллагаа тогтоох талаар уулзаж ярилцав. Энэ үеэр УИХ-ын гишүүн Н.Энхболдын санаачилгаар БНСУ-ын Пёнтак хотын хөрөнгө оруулалтаар аймгийн Нийтийн номын санд засвар шинэчлэл хийх ажлыг эхлүүлэхээр болов. Түүнчлэн Сөүл хотын их сургуультай танилцах үеэр тус Их сургуулийн Ерөнхийлөгч Со Сүн Таг болон төгсөгчдийн холбооны тэргүүн нар манай төлөөлөгчдийг хүлээн авч уулзан Сөүлийн Их сургуулийн салбар сургуулийг Төв аймагт байгуулах тухай ярилцан, санал нэгдэв.

Төв аймгийн Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөгчид 2019 оны 8 дугаар сарын 19-өөс 22-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймагт ажилласан.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төв: 2019 оны 08 дугаар сарын байдлаар Төрийн болон бизнесийн, дэмжих үйлчилгээний нийт 21 байгууллага 300 гаруй төрлийн үйлчилгээг 4600 гаруй иргэнд, өдөрт дунджаар 350 иргэнд шуурхай хүргэн ажиллаа.

Аймгийн веб сайтад **18**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **34** мэдээ мэдээлэл нийтлэгдсэн. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв аймгийн цаг” нэвтрүүлгийн **4-н** дугаар, мөн бусад телевизүүдийн мэдээний цагаар давхардсан тоогоор **62** мэдээ мэдээллийг бэлтгэн иргэд, олон нийтэд хүргэлээ.

7027-1111 нээлттэй утсанд төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой 2 гомдол санал ирснийг холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэв.

Мэргэжлийн хяналтын газрын үйлчилгээ: Тайлант хугацаанд төлөвлөгөөт шалгалтаар 13, төлөвлөгөөт бус шалгалтаар 3, харьяаллын дагуу шилжиж ирсэн 5, нийт 21 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, 18 хуулийн этгээд, нэг иргэнд 34,6 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулалтын шатандаа байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалт: Мэргэжлийн хяналтын байгууллагын 2019 оны нэгдсэн төлөвлөгөө, Мэргэжлийн хяналтын газрын даргын баталсан удирдамжийн дагуу Байгаль орчин, Геологи, уул уурхай, Хөдөлмөр, Нийгмийн хамгаалал, Газар, геодези зураг зүй, Эрчим хүч, Хэмжил зүй, Харилцаа холбоо, Авто тээвэрийн хяналтын чиглэлээр Төв аймгийн Заамар сумын нутагт уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 14 аж ахуйн нэгжид шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 6 объектод улсын ахлах байцаагчийн хамтарсан 42 заалт бүхий албан шаардлага, 7 объектын улсын ахлах байцаагчийн хамтарсан 32 заалт бүхий зөвлөмж, 1 объектын үйл ажиллагааг улсын ахлах байцаагчийн 3 заалт бүхий актаар үйл ажиллагааг нь зогсоож, Зөрчлийн тухай хуулийн дагуу байгаль орчны хяналтын чиглэлээр 4 сая, геологи уул уурхайн чиглэлээр 6,5 сая, харилцаа холбооны хяналтын чиглэлээр 500 мянга, хэмжилзүйн хяналтын чиглэлээр 1 сая,

нийгмийн хамгааллын чиглэлээр 2 сая төгрөг нийт 14 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, холбогдох зөрчлийг арилгуулж ажилласан.

Хүнс, эрүүл ахуйн хяналтын чиглэлээр Зуунмод суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Чансаа”, ЗДТГ-ын “Зоогийн газар”, “Өгөөж” хүнсний дэлгүүр, “Зуунмод” мах боловсруулах үйлдвэрт шалгалт хийж улсын байцаагчийн хамтарсан 35 заалт бүхий албан шаардлага хүргүүлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын төвд баригдах 920 сурагчтай сургуулийн барилгын ажлын зураг, Баянцагаан сумын 5-р багийн нутагт баригдах Хаан банкны тооцооны төвийн барилгын ажлын зургуудад буцаах дүгнэлт 2, Эрдэнэ сумын 5-р багийн нутагт баригдах Мах боловсруулах үйлдвэрийн өргөтгөлийн барилгын ажлын зурагт зөвшөөрөх тухай улсын байцаагчийн дүгнэлт гаргасан.

Автотээврийн хяналтын чиглэлээр Заамар суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 3 объектод төлөвлөгөөт шалгалт, 4 объектод төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага хүргүүлсэн.

Эрүүл мэндийн хяналтын чиглэлээр Баянчандмань, Борнуур суманд сувиллын үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 19/133, 19/134 тоот удирдамжийн дагуу шалгалт болон зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж байна.

Төлөвлөгөөт бус шалгалт: Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр “Таван толгой түлш” ХХК-ийн үйл ажиллагаанд хуулийн хэрэгжилт, тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, стандартын мөрдөлтөд баримт бичигт тулгуурлан газар дээр нь хяналт шалгалт хийж, Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 5.2 дахь заалтын дагуу 3000 нэгж буюу 3 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авч, эрх бүхий албан тушаалтны даалгаврыг хүргүүлэв.

Төв аймгийн Цагдаагийн газраас Сэргэлэн сумын Баянбүрд 1-р багийн нутагт үйл ажиллагаа явуулдаг “Мөнхийн баян гал” ХХК-ийн 4 ажилтан газанд хордон эмнэлэгт хүргэгдсэн гэх хэргийн материалтай танилцаж, шалган Зөрчлийн тухай хуулийн 10.15 дугаар зүйлийн 2 дахь заалтын дагуу 4000 нэгж буюу 4 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авлаа.

Аргалант суманд үйл ажиллагаа явуулж буй “Эко Фүүдс Трэйд” ХХК -д шалгалтын ажлыг хяналтын хуудасны хүрээнд хийж гүйцэтгэлээ. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн хамтарсан албан шаардлага өгсөн. Үүсээд байгаа гол асуудал нь сумын удирдлагууд малын гаралтай хаягдлыг энгийн хог хаягдалтай адилтгаж хаяулахаар шийдвэр гаргаж 30х40 хэмжээтэй том нүх 5 сард бий болгосноор энэхүү замбараагүй хаягдлын эх үүсвэр бий болсон байна. Тус ААН нь 8 дугаар сарын 14-нд үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхлүүлэхэд хур хог үүссэн байсан гэх бөгөөд Эмээлт орчмын ААН-үүд дур мэдэн хаясан нь баримтаар нотлогдож байна. Сумын удирдлагуудад цаашид энгийн хог хаягдлын цэг болон устгалын цэгийг тусад нь ялгах, бүртгэх, хаягжуулж тэмдэгжүүлэх, 30х40 хэмжээтэй том нүхийг устгалын цэгээр бүртгэж орчмын хорио цээр түр тогтоох үүрэг өглөө.

Бусад хяналт: Ургамал хамгаалал хорио цээрийн хяналтын чиглэлээр шинэ ургацын хүнсний ногооны 5 дээжийг сорилтын лабораторит пестицид, нитрат, нитритийн агууламж тодорхойлуулах шинжилгээнд хамруулсан.

Аймгийн Засаг даргын 2019 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн А/452 тоот захирамжийн дагуу Ургацын урьдчилсан баланс тогтоох ажлын хэсэг, Таримлын сортын хянан баталгааг хийхээр тариалан бүхий 15 суманд 2 групп ажилласан.

Боловсролын хяналтын чиглэлээр хичээлийн шинэ жилийн бэлтгэл, элсэлтийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Зуунмод сумын 4 ерөнхий боловсролын сургууль, 7 сургуулийн өмнөх байгууллагын 20 объектод, Жаргалант, Борнуур, Баянчандмань сумын 16 объектод хийж, хууль

тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллаж байна.

Зуунмод, Баянхангай суманд хүнсний чанар, стандартын хяналтын чиглэлээр иргэний гомдлын дагуу хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч 2 иргэнд 19/28 дугаартай удирдамжийн дагуу төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийн илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 18 заалттай, 2 албан шаардлага хүргүүлээ.

Итгэмжлэгдсэн лаборатори нь өнгөрсөн сарын хугацаанд төлөвлөгөөт хяналт шалгалт, ААН, иргэний хүсэлтийн хүрээнд 90 сорьцыг шалгаж хүлээн авч 229 үзүүлэлтээр сорилыг гүйцэтгэн үр дүнг баталгаажуулан хугацаа хэтрүүлэхгүй олгов.

Онцгой байдлын газрын хүрээнд: Онцгой байдлын газрын Ёс зүйн алба 8 сард 2 удаа хуралдаж сахилга ёс зүйн зөрчил гаргасан 3 алба хаагчийн асуудлыг хэлэлцэж, газрын ёс зүйн албаны санал дүгнэлтийг газрын даргад уламжиллаа. Газрын дотоод хяналт шалгалтын зөвлөл төлөвлөгөөний дагуу авто машин, техник хэрэгслийн бэлтгэл бэлэн байдалд үзлэг шалгалтыг зохион явуулж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах үүрэг даалгаврыг хариуцсан алба хаагч нарт өгч хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна.

Мөнгөнморьт сум дахь Гал түймэр унтраах, аврах 75 дугаар анги, Лүн Баян сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн барилгын засвар, шинэчлэл, бүтээн байгуулалтын ажлыг Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүн, сумын Засаг даргын тамгын газартай хамтран гүйцэтгэж байна. Мөн Батсүмбэр сум дахь Гал түймэр унтраах, аврах ангийн барилгын шавь тавих ёслолын арга хэмжээг сумын удирдлага, ард иргэд, Онцгой байдлын газрын бие бүрэлдэхүүнийг хамруулан зохион байгуулж, Онцгой байдлын газрын алба хаагчид Гал түймэр унтраах, аврах ангийн барилгын суурийн ажлыг гүйцэтгэж байна.

Монгол Улсын Шадар Сайдын баталсан хяналт шалгалтын удирдамжийн дагуу Боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Хүмүүн ахлах сургууль, 4-р сургууль, Монгень 5-р сургууль, Бага сургууль, Бүжинхэн, Дэгдээхэй, Ирээдүй, Бумбардай, Унагалдай, Сентпоул зэрэг 11 сургууль, цэцэрлэгийн барилга байгууламжид болзошгүй аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослоос хамгаалах, гамшиг осол, гал түймрийн аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтыг зохион байгуулж ажилласан.

Онцгой байдлын ерөнхий Газрын даргын 2019 оны 2 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Авто үйлчилгээний байгууллагуудад галын аюулгүй байдлын тухай хууль, норм нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах хяналт шалгалтын удирдамжийн дагуу Зуунмод сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа “Төв АЗЗА” ТӨХК-ний авто граж, “Манзушир өргөө” хорооллын 1,2-р блок барилгийн авто граж, “Төвт хайрхан” ХХК-ний Авто аз төв засвар үйлчилгээ “Тисэм цамхаг” ХХК-ний авто угаалгын газар, “Авто угаалгын” газруудад хяналт шалгалт явуулсан.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 19 байгууллага, аж ахуйн нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 124 зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 38 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтанд зааварчилгаа зөвлөгөөг өгч ажилласан байна.

Барилга байгууламж шинээр ашиглалтанд орох улсын комисст 5 удаа ажиллаа.

Галын аюулгүй байдлын дүгнэлт зөвшөөрөл сунгуулах болон гаргуулахыг хүссэн иргэн, аж ахуй нэгжийн 29 объектыг шалгаж, шаардлага хангасан 27 аж

ахуй нэгж байгууллагад гал түймрийн улсын хяналтын байцаагчийн галын аюулгүй байдлын дүгнэлт олгов.

Объектын гал: 2019 оны 08 дугаар сарын 04-ний өдөр Батсүмбэр сумын Үдлэг 4 дүгээр багийн нутаг Бөөрийн ар гэх газард иргэн Ц.Бат-Очирын эзэмшлийн 5 ханатай гэр, эд зүйлийн хамт бүрэн шатсан. Уг түймэрт Б.Сэр-Од /3 настай эрэгтэй/ нас барж, Б.Галбаяр /10 настай эрэгтэй/ нүүрэн хэсэг, Б.Номинчимэг /2 настай эмэгтэй/ 30% түлэгдэлтэй гарсан байна.

2019 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Заамар сумын төв 4 дүгээр багийн хойд дэнж 3 дугаар хэсгийн задгай тоотод иргэн Д.Бямбасүрэнгийн эзэмшлийн 4,5 ханатай 2 гэр, эд зүйлийн хамт шатсан байна.

Аадар бороо: 2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт хүчтэй аадар бороо орсны улмаар Зэвсэгт хүчний 314 дүгээр ангийн 210 м блокон хашаа нурж, хүнсний склад, спорт заал, бензин насосын станц усанд автаж байгууллагын өмчөнд 6,219,000 төгрөгийн хохирол учирсан байна.

2019 оны 08 дугаар сарын 05-ны өдөр Баян-Өнжүүл сумын 1-р багийн нутаг дэвсгэр Тэргэт гэх газар хүчтэй аадар бороо орсны улмаар иргэн Б.Батболдын том, жижиг гэр, гэрт байсан 28 нэр төрлийн зүйл үерт автаж хувийн өмчид 8,570,000 төгрөгийн хохирол учирсан байна.

Эрэн хайх, аврах ажиллагааны үр дүнд 2 иргэнийг аварсан.

Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 12 дугаар хуралдаанаар “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл”-ийг мэдээ, мэдээллээр хангах орон тооны байнгын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажиллах журам, ажлын хэсгийг мэдээллээр хангах журам, мэдээ, мэдээллийн жагсаалтыг тус тус шинэчлэн батлуулж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албанд хүргүүлээ.

ХЗДХЯ, ХЗС-тай хамтран Зууны мэдээ сонины 7 хоног тутмын “Хуульч зөвлөж байна” асуулт хариултын булан, Монголын радиогийн сар тутмын “Хуулийн цаг” зохиомжит нэвтрүүлгийн 8 сарын дугааруудыг бэлтгэн нийтэд хүргэв.

Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 38 шийдвэр, гэрээний хууль зүйн үндэслэлийг хянаж, зөвлөмж өгч, хууль, эрх зүйн асуудлаар нийт 49 иргэн, байгууллагад эрх зүйн туслалцаа үзүүлж, Дотоод удирдлагын системээр шинэ хууль тогтоомжийн 24 мэдээлэл оруулж, төрийн албан хаагчдыг хууль, эрх зүйн мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Сумдын эрх бүхий албан тушаалтнуудаас батлан гаргасан захиргааны 2 шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, хуульд нийцүүлэн зөвлөмж хүргүүлэв. Аймгийн Захиргааны хэргийн шүүхэд аймгийн Засаг даргыг төлөөлж 4 хэргийн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож тайлбар дүгнэлт гаргаж, шүүх хуралдаанд оролцож ажиллав.

Архивын үйлчилгээ: Тайлант хугацаанд архивын эх баримтаас 118 иргэний хүсэлтээр 364 хуулбар хувь, 70 лавлагаа гарган үйлчилсэн бөгөөд 770.00 төгрөгийн орлого төсөвт төвлөрүүлэв. 2 хөмрөгийн 71 хадгаламжийн нэгжийн 6792 хуудас баримтын 21929 хүний нэр, заалт, 6115 тушаалын тоон мэдээллийг програмд хадгаламжийн нэгжийн түвшинд шивж, скайнердаж PDF.JPEG хэлбэрт хувиргав.

Улсын бүртгэлийн үйлчилгээ:

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр: Тайлант хугацаанд цахим санд нийт 51,238 хувийн хэрэг байгаагаас Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 9558, Газар өмчлөх эрхийн 41,680 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 21,654.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр: Тайлангийн хугацаанд нэмэлт өөрчлөлтийн бүртгэлд нийт 162 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлж, 127 хуулийн этгээд үүсэн байгуулагдсан. Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 40, хууль хяналтын байгууллагад 38 лавлагаа мэдээллээр үйлчиллээ. Орон нутгийн төсөвт 9067.0 төгрөгийг орууллаа.

Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр: /өссөн дүнгээр/: Иргэний гэр бүлийн байдлын 2092 бүртгэл, иргэний үнэмлэх захиалгын нийт 3095 бүртгэл, шилжин суурьших хөдөлгөөний бүртгэлд нийт 1274 иргэн бүртгүүлж, үндэсний энгийн гадаад паспортыг 82 иргэнд олгоод байна.

Хяналт шалгалтын чиглэлээр: Иргэний улсын бүртгэл, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл, Хуулийн этгээдийн улсын бүртгэл, улсын бүртгэлийн архивын нийт 11533 бүртгэлд хяналт шалгалт хийж 155 бүртгэлийн зөрчил илрүүлж хуулийн хугацаанд зөрчлийг арилгасан. Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрсөн 694 иргэн, хуулийн этгээдэд торгох шийтгэл оногдуулж 18.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэв. Иргэдээс ирүүлсэн 94 өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэлээ.

Цагдаагийн газрын ажил ажиллагааны хүрээнд: Энэ сард 511 гэмт хэрэг бүртгэгдэж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 99 нэгжээр буюу 19,3 хувиар өссөн, зөрчил 33420 бүртгэгдэж 4832 нэгжээр буюу 14,4 хувиар буурсан үзүүлэлттэй, гэмт хэргийн илрүүлэлт 38,4 хувьтай байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 4.6 хувиар өссөн байна.

Нийт бүртгэгдсэн гэмт хэрэгт Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 30,7 хувь, Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 10,6 хувь, үүнээс мал хулгайлах гэмт хэрэг 60 хувь, Хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 42,4 хувиар тус тус өсч, гэр бүлийн хүчирхийлэл 29,3%, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдэгдсэн гэмт хэрэг 23,2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах зорилгоор “Улсын дугаар-2019”, “Орон нутгийн зам-хөдөлгөөн соёл 2019”, “Нийгэмлэг”, “Мөнгө угаах”, “Хичээлийн шинэ жил”, “Яараад яахав дээ” зэрэг нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээ, аян, орон нутагт үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын онцлогт тохируулан хөдөлгөөний аюулгүй байдлын чиглэлээр “Оргодол, “Хяналт шалгалт”, малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Ололт” хэсэгчилсэн арга хэмжээг тус тус зохион байгуулж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа: Гудамж талбай, олон нийтийн газар болон гэр орон, ахуйн хүрээндээ архи дан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгслэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй болтлоо согтсон-39, шүүхээр баривчлагдсан-44, албадан саатуулагдсан-10 нийт 93 иргэнийг эрүүлжүүлэх, саатуулах байранд код журмийн дагуу биед болон эрүүл мэндийн үзлэг хийж хүлээн авч ажилласан.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хамгаалалтад 15 удаа 258 алба хаагч 120 тээврийн хэрэгсэлтэй 600 тусгай хэрэгсэл, 54 холбооны хэрэгсэлтэй 780 хүн/цагийн үүрэг үүрэг гүйцэтгэж 19650 иргэдийн аюулгүй байдлыг хангаж ажиллалаа.

Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр: Согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 44 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилээр хасаж, хуульд заасны дагуу 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл

жолоодож хөдөлгөөнд оролцсон 20 иргэнийг сум дундын сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, ЦЕГ-ын туслах тоо бүртгэлийн санд мэдээллийг бүртгэж ажиллалаа. Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрэм, холбогдох хууль тогтоомж зөрчсөн нийт 5082 жолоочийг 146.2 сая төгрөгөөр торгож ажилласан байна.

Шүүхийн шинжилгээний чиглэлээр: Тайлант хугацаанд Криминалистикийн шинжилгээ-100, Нийт хийсэн магадлан шинжилгээ-83, Хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр-268, гарын мөрийн санг баяжуулсан-152, гэмтлийн зэрэг тогтоох үзлэгийн дүгнэлт 401 хийгдсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээр:

Шийдвэр гүйцэтгэлийн бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохих	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
08-сар	398	394	72	720	311	409	43.2
	3920610.2	4060057.4	1662010.8	6318656.8	1518763.7	4799893.1	

Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд

ХАА-н чиглэлээр: Хөдөө аж ахуйн салбарын цаг үеийн төлөвлөгөөт ажлыг эрчимжүүлэхээр 27 суманд газар тариалан, мал аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэл, сум хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд шалган туслах ажлыг зохион байгуулсан.

Газар тариалан: Аймгийн хэмжээнд ургац тогтоож, ургацын урьдчилсан балансыг гаргах 2 ажлын хэсгийг 8 дугаар сарын 14-ний өдрөөс 19-ний хооронд ажиллуулсан. Аймгийн шууд харилцаат Япон улсын Тоттори мужийн Гадаад харилцааны хэлтэс, Хөдөө аж ахуйн сургуультай хамтран Зуунмод, Жаргалант, Сүмбэр, Баянчандмань, Баянцогт сумдын өрхийн тариаланч болон хүлэмжийн аж ахуй эрхлэгчдэд “Хамгаалагдсан хөрсөнд гүзээлзгэнэ, тарвас, навчит ногоог ургуулах арга технологи”, “Таримлын өвчин, хортон түүнээс урьдчилан сэргийлэх, тэмцэх”, “Шим тэжээлийн бодисын дутагдалыг таних, ялгах, бордох” зэрэг сэдвээр 5 удаагийн сургалт зохион байгуулж 82 хүнийг хамруулж, 13 аж ахуйн нэгж, иргэний талбайгаар явж зөвлөгөө өгч, гарын авлагаар хангасан.

БНСУ-ын Канвон муж болон аймгийн хөрөнгө оруулалтаар Зуунмод суманд “ЭКОЛОГИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ТӨВИЙН ХҮЛЭМЖ”-ийг шинээр барьж, ашиглалтад оруулж, төвийн нээлтийн арга хэмжээг зохион байгуулав.

Мал аж ахуй: Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 26 суманд 36 инженерийн хийцтэй худаг гаргахаас 27 худаг шинээр гарч, 25 худгийг сумдын ЗДТГ-т хүлээлгэн өглөө.

Малчин, мал бүхий иргэд 121,8 мянган тн хадлан, 35,5 тн гар тэжээл бэлтгэх аймгийн Засаг даргын шийдвэр гарсан. Тайлант хугацаанд **1020,1** тн хадлан, **121** тн гар тэжээл бэлтгээд байна. Аймгийн аюулгүйн нөөцөд 100 тн өвс нийлүүлэх тендер зарлан Зуунмод, Цээл, Лүн сумдын хадланчдад урилга хүргүүлэв.

Үйлдвэрлэл, үйлчилгээ: ХХААХҮ-ийн сайдын 2019 оны А/119 дүгээр тушаалаар баталсан “Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас урт хугацаатай, хөнгөлөлттэй зээл олгох, төсөл сонгон шалгаруулах журам”-ын хүрээнд аймгийн ЖДҮХСанд 2.4 тэрбум төгрөгийн зээл хүссэн 15 сумын 38 иргэн, аж ахуй нэгжийн

төслийг хүлээн авч, шалгаруулахад 1-р шатанд 1081.8 сая төгрөгийн 15 төсөл буцаагдаж, 1411.6 сая төгрөгийн 23 төслийг дэд хорооны хурлаар хэлэлцүүлж, нийт 4 аж ахуйн нэгж, 13 иргэний 1.0 тэрбум төгрөгийн төслийн жагсаалтыг аймгийн Засаг даргын 2019 оны А/456 дугаар захирамжаар баталгаажуулсан.

ХАА-н хоршоологчдын улсын зөвлөгөөн "Хөдөө аж ахуйн хоршоодын бүтээгдэхүүний маркетинг" сэдвийн дор 2019 оны 8 сарын 4-7-ны өдрүүдэд Төв аймгийн Эрдэнэ суманд амжилттай зохион байгуулагдлаа. Энэхүү улсын зөвлөгөөнд 21 аймгийн 260 гаруй хоршоологчид оролцож ХАА-н хоршоодын бүтээгдэхүүн хөгжүүлэлт, борлуулалт, өртгийн сүлжээнд тулгарч буй асуудлыг тодорхойлж, гишүүн хоршоодын тэргүүн туршлагаас хуваалцаж, Эрдэнэ сумын "Хонины ноосон биобордооны үйлдвэр", "Эрдэнэ хүнс" ХХК-ийн "Мах боловсруулах үйлдвэр"-тэй танилцлаа.

НҮБ-ын ХХААБ-ийн SICEM-2 төсөлтэй хамтран Баянчандмань сумын "Сүүн далай оргил" хоршооны "Сүү боловсруулах үйлдвэрийг түшиглсэн "Сүү үйлдвэрлэгч бүлэг, хоршоо байгуулахад дэмжлэг үзүүлэх" сэдэвт сургалтыг зохион байгуулсан.

Мал эмнэлгийн үйлчилгээ: Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 12 нэр төрлийн вакцинжуулалтад 1467,8 мян.мал хамруулахаар төлөвлөн 1335,6 мян.малыг хамруулж 91%-тай, эмбио бэлдмэлийн нийлүүлэлт 100%-тай байна.

Гоц халдварт Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтад 10 сумын 3858 өрхийн 1188,2 мян.тол мал хамруулахаас 1182,0 мян.тол мал хамруулж, гүйцэтгэл 99,4%-тай гүйцэтгэсэн.

Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний туулгалтад 1100,0 мян.мал хамруулахаас 952,4 мян.мал буюу 86,5%, боловсруулалтад 1100,0 мян.мал хамруулахаас 878,4 мян.мал буюу 79,8%-ыг, угаалгад 39,475 толгой бод, 536,895 толгой бог малыг тус тус хамруулаад байна.

Мал эмнэлгийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт 2,130.477 толгой малыг хамруулсан.

Аймгийн хэмжээнд 1150.0 мян.м2 талбайд ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулахаар төлөвлөн 885,5 мян.м2 талбай буюу 77%-ийг хамруулаад байна.

Ийлдэс судлалын шинжилгээ: Цээл, Бүрэн, Өндөрширээт, Дэлгэрхаан сумдын 60 өрхийн 300 үхэр, 450 хонь, 450 ямаа, бүгд 1200 малаас цусны дээж авч, ийлдсийг газар дээр нь ялган, дээж тус бүрийн дагалдах хуудсыг бичиж, газар зүйн байрлал, нас, хүйсийг тодорхой тэмдэглэн, хөргүүрт тээвэрлэн аймгийн лабораторид Eliza урвалаар шинжилгээ хийж байна.

Хөрөнгө оруулалт, барилга хот байгуулалтын үйлчилгээ:

Зуунмод сумын Номт багийн "Хөгжил хотхон"-ы баруун талд байршилтай газрын дуудлага худалдаагаар зарагдсан 42 нэгж талбарын газруудад дэд бүтэц байгуулах ажлын зураг төслийг "ДНТ" ХХК-иар гүйцэтгүүлж, тендер зарлагдан дулаан хангамж, ариутгах татуурга, цэвэр усан хангамжийн ажлын гүйцэтгэгчээр "Баткомплект" ХХК шалгаран гэрээ байгуулан ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин баригдаж байгаа 6 барилга байгууламжид захиалагчийн хяналт гүйцэтгэж байна.

МУЗГ-ын 2018 оны 68, 171 дүгээр тогтоолуудын хүрээнд 50 барилга байгууламж эхлүүлэх зөвшөөрөл олгов. Аймгийн хэмжээнд 8 дугаар сард 6 барилга байгууламж ашиглалтад өгсөнөөр нийт 19 барилга, байгууламжийг ашиглалтад хүлээн авсан.

Түрээсийн 12 орон сууцанд 42 иргэдэд хамрагдаж түрээсийн гэрээ байгуулан ажиллаж байна. Барьцааны нийт 5,450,385 төгрөг, 11 айлын түрээсийн төлбөр график хугацаандаа хийгдсэн.

Газрын харилцааны үйлчилгээ: Газрын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад анхаарах асуудлаар Лүн, Баянхангай, Угтаалцайдам суманд зөвлөн туслах ажиллагаа явуулсан. Тус ажлын хүрээнд Лүн суманд үүссэн газрын маргааныг шийдвэрлэх талаар зөвлөмж, зааврыг газрын даамалд өгч, геодезийн хэмжилт тодруулалтыг газар дээр нь хийв.

ГЗБГЗЗГазар, бэлчээрийн “Ногоон алт” төсөлтэй хамтран “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх, дүгнэх аргачлал”-ын талаарх сургалтыг 24 сумын газрын даамлыг хамруулан зохион байгууллаа.

2014-2019 оны Газрын төлбөрийн нэгтгэлийг Газрын нэгдмэл сангийн 6 ангиллаар гаргаж, Сангийн яаманд 2020 оны газрын төлбөрийн төлөвлөгөөний төслийг нэгтгэн, 2,7 тэрбум төгрөгөөр хянуулсан.

Газрын төлбөрийн орлого 1096,8 сая төгрөг төвлөрүүлэхээс 1845,8 сая төгрөг төвлөрч 168,2 хувийн биелэлттэй байна.

Байгаль орчны чиглэлээр: БОАЖЯ-ны Ойн бодлого зохицуулалтын газар, ШУА-ын Газарзүй гео-экологийн хүрээлэнгийн судлаачидтай хамтран, байгаль хамгаалагч, ойн нөхөрлөлийн гишүүд, иргэдэд “Ойн хортон шавжийг ялган таних арга зүй”-н сургалтыг Батсүмбэр суманд зохион байгуулсан.

Эрдэнэ суманд үйл ажиллагаа эрхэлж буй аялал жуулчлалын бааз, амралтын газруудад “Байгаль орчныг хамгаалах тухай”, “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай”, “Хог хаягдлын тухай”, “Усны тухай”, “Аялал жуулчлалын тухай” хуулиуд болон 2019 оны байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, Аймгийн ИТХ-аар батлагдсан “Ус үндэсний дэд хөтөлбөр”, “Аялал жуулчлалыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”, “Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг шалгаж, зөвлөн туслах ажил хийгдэж байна.

Стандарт хэмжил зүйн үйлчилгээ: 2019 оны 08 дугаар сарын байдлаар Баталгаажуулалтын зөвлөлийн хурлыг 7, Баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлыг 5 удаа нийт зохион байгуулсан.

Тайлант хугацаанд Зуунмод, Батсүмбэр, Баян, Баян-Өнжүүл, Эрдэнэсант, Аргалант сумдад ээлжит баталгаажуулалтаар ажилласан. Сэргэлэн, Эрдэнэ, Жаргалант, Борнуур, Баянчандмань, Аргалант, Батсүмбэр сумдад үйл ажиллагаа явуулж буй хүсэлтээ ирүүлсэн 20 жуулчны бааз, амралтын газарт үнэлгээ хийж 17 жуулчны бааз, амралтын газарт Баталгаажуулалтын зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Тохирлын гэрчилгээ олгов.

Тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулахаар хүсэлт ирүүлсэн 183 бүтээгдэхүүн үйлчилгээг тохирлын үнэлгээнд хамруулж, 160 бүтээгдэхүүн, үйлчилгээнд гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаагаар олгосон.

Хэмжил зүйн нэгдсэн лабораторид Зуунмод, Баян, Батсүмбэр, Эрдэнэсант, Борнуур, Жаргалант, Сүмбэр, Сэргэлэн, Эрдэнэ, Баянжаргалан, Баянчандмань, Архуст, Мөнгөнморьт, Заамар сумдын худалдаа, үйлчилгээний тооцоо, хүн, мал эмнэлгийн шинжилгээ, эмчилгээ оношлогоонд ашиглагдаж байгаа нийт 3788 ш хэмжүүр, хэмжих хэрэгслийг ээлжит баталгаажуулалтад хамруулсан.

Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:

2019 оны 08 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд Нийгмийн бодлогын хэлтсийн харьяа байгууллагуудын “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг Заамар сумын төв

болон Хайлааст багт зохион байгуулж, багийн айл өрхөөр орж иргэдтэй уулзалт хийж, боловсрол, нийгмийн даатгалын үйлчилгээ, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрүүд болон нийгмийн халамжийн ганцаарчилсан зөвлөгөө үзүүлэх, зөөврийн номын сан мөн Халдварт болон ХБӨ-ний эрт илрүүлэг үзлэг, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг үэрэг үйлчилгээг давхардсан тоогоор 5584 иргэнд хүргэлээ.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, Багшийн мэргэжил дээшлүүлэх институт, Боловсролын хүрээлэн хамтран “Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх арга зүй” сэдэвт сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 15-18-ны өдрүүдэд Зуунмод хотод зохион байгуулахад ерөнхий боловсролын 31 сургуулийн 850 багш, 107 удирдах ажилтан, СӨБ-ын 250 багш, нийт 1207 багш хамрагдлаа. Аймгийн нутгийн удирдлагын байгууллага, ИТХ-ын төлөөлөгч нартай хамтран энэхүү сургалтад хамрагдсан 1200 гаруй багш нарт хүндэтгэл үзүүлж, “Багшийн алдар” уулзалт, хүндэтгэлийн үйл ажиллагааг анх удаа зохион байгуулан, амжилт гаргасан багш нарыг шагнаж урамшуулав.

Боловсрол, соёл, урлагийн газрын үйлчилгээ: 2019 оны 8 дугаар сарын 26-ны өдөр Төв аймгийн “Багш нарын бага хурал”-ыг боловсролын байгууллагын удирдлагууд, нийгмийн ажилтан, сургалтын менежерүүд нийт 170 гаруй багш, удирлагыг хамруулан зохион байгууллаа. Бага хурлаар өнгөрсөн онд Боловсролын салбарт дэвшүүлсэн зорилго, зорилтын хэрэгжилтийг дүгнэж, энэ хичээлийн жилд хэрэгжүүлэх зорилго, зорилтоо тодорхойлов. 2019-2020 оны хичээлийн жилд “Сургалтын сайжруулсан хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын багш бүр хичээл, сургалтын бэлтгэлийг чанартай ханган, үр дүнтэй зохион байгуулж, багш, эцэг эх, асран хамгаалагчийн оролцоо, хамтын ажиллагааг өргөжүүлэх замаар хүүхэд бүрийн төлөвшил сурлагын чанарт ахиц гаргах” зорилго дэвшүүлсэн. Мөн 2018-2019 оны хичээлийн жилд дэвшүүлсэн зорилтоо амжилттай хэрэгжүүлэн хүүхэд багачуудыг сурган хүмүүжүүлэх их үйлсэд өндөр амжилт гаргасан багш, хамт олныг алдаршуулан шагналаа.

Албан бус насан туршийн боловсролын төвийн үйлчилгээ: ДЗОУБ, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хүүхдийн эерэг хүмүүжлийн арга” сургалтыг АБНТБТ-ийн багш, нийгмийн ажилтан, цэцэрлэгийн арга зүйч зэрэг 70 албан хаагчийн хамруулан зохион байгуулав.

Театрын үйлчилгээ: 2019 оны 08 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд БНСУ-ын Соёлын солилцооны төлөөлөгчид урлагийн тоглолт, Солонгос үндэсний хоол, цайг сурталчилах арга хэмжээг зохион байгууллаа

Музейн үйлчилгээ: Тайлант хугацаанд нийт 1905 үзэгчдэд үйлчилгээ үзүүлж, 1.6 мян.төг-ийн орлого олж, өссөн дүнгээр 6.6 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 9488 үзэгчдэд үйлчлээд байна. Музейн мэргэжил арга зүйн зөвлөлөөс Төв музейн 1-р танхимын үзмэрийн тайлбарыг шинэчлэн гаргаж байрлууллаа.

Нийтийн номын сангийн үйлчилгээ: 2019 оны 8-р сард **100** байнгын уншигч, **450** ирэгсэд, нийт **550** уншигчдад **1800** ном олгож уншууллаа. Уншигч хүүхдүүдийнхээ зуны амралтыг тохиолдуулан “Миний унших номнууд” номын үзэсгэлэнг 30 номоор сэдэвчлэн гаргасан. Номын сангийн фондонд хадгалагдаж байгаа А-К хүртэлх номыг үсэг дарааллын каталогийн карт бичиж, уншигчдын хүртээл болгосон.

Биеийн тамир, спортын үйлчилгээ: Аргалант суманд зохион байгуулсан “Төв түмний цэнгэл-2019” баяр наадам бөхийн барилдаанд 128 бөх, шагайн

харваанд 182 харваач, үндэсний сурын харваанд 35 харваач, нийт 345 тамирчин оролцлоо.

“Богд хан уул”-ын марафон олон улсын гүйлтийн тэмцээн 2019.07.28-нд зохион байгуулагдаж 5 орны 300 гаруй тамирчин хамрагдсан.

“Өлзийт нуур”-ын шагайн 21 дэх удаагийн тойром харваа 2019.08.03-04-ний өдрүүдэд Баянцагаан суманд МУ-ын хүндэт харваач “Мэргэн долоовор” хэмээх Пунцагийн Жамсрандоржийн нэрэмжит болон зохион байгуулагдаж 18 сумын 23 багийн 184 харваач оролцлоо.

“ТӨВ–2019” Спорт бүжгийн насанд хүрэгчдийн стандартын формейшн улсын аварга шалгаруулах тэмцээн 08 дугаар сарын 10-ны өдөр Зуунмод суманд зохион байгуулагдсан бөгөөд тус тэмцээнд 15 байгууллагын 280 хүн /эрэгтэй 140, эмэгтэй 140/ оролцсон.

Төв аймгийн уугуул Монгол Улсын гавьяат дасгалжуулагч Л.Жамьяасүрэн, Монгол Улсын гавьяат тамирчин Д.Дэмбэрэл нарын нэрэмжит Олон улсын байт харвааны тэмцээн 18 дахь удаагаа зохион байгуулагдаж 70 гаруй тамирчид оролцов.

Эрдэнэсант суманд “Хөдөлгөөн эрүүл мэнд 2019” зүүн бүсийн ахмадын өдөрлөг 10 сумын 11 багийн дунд 4 төрлийн тэмцээн зохион байгуулж, нийт 140 иргэн оролцсон.

2019 оны 8-р сард олон улсын кросс гүйлт, бүжиг, ахмадын бүсийн өлөрлөг, нээлттэй хаалганы өдөрлөг, байт харвааны тэмцээнүүдийг зохион байгуулж, нийтийг хамарсан арга хэмжээг 7 удаа явуулж, 1485 тамирчин хамрагдаж улсын аварга шалгаруулах тэмцээнээс 25 медаль хүртлээ.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын үйлчилгээ: Тус сарын “Хүүхдээ сонсох өдөр”-өөр аймгийн Засаг даргын орлогч Ч.Сарангэрэл, ГБХЗХГ-ын дарга Д.Бадамцэцэг нар Батсүмбэр суманд Скаутын цугларалтад амарч байгаа 150 гаруй сурагчидтай уулзалт зохион байгууллаа.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, ДЗМОУБайгууллагын Төв орон нутгийн хөтөлбөртэй хамтран “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга нэгдье” сургагч багш бэлтгэх сургалтыг 27 сумын Боловсролын нийгмийн ажилтан, албан бус насан туршийн боловсролын төвийн багш, цэцэрлэгийн арга зүйч 70 багш хамруулан зохион байгуулна.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээ: 2019 оны 8 дугаар сарын байдлаар /өссөн дүнгээр/ 1857 иргэнд 2411.8 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1192 иргэнд 661.4 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 1092 иргэнд 441.9 сая төгрөгийн амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, 1583 ахмад настанд 241.3 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, 397 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 78.2 сая төгрөгийн тусламж хөнгөлөлт, жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй 1599 эхэд 239.7 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Алдарт эхийн одонтой 9017 эхэд 1211.0 сая төгрөг, алдар цолтой 59 ахмад настанд 74.1 сая төгрөг, 4975 ахмад настанд 420.1 сая төгрөгийн насны хишгийг олголоо. 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 5403 эхэд 1776.4 саятөгрөгийн тэтгэмж, 3 ба түүнээс дээш тооны 18 хүртлэх насны хүүхэдтэй өрх толгойлсон 276 эх /эцэг/-т 160.1 сая төгрөгийн тэтгэмж олгов.

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг нэг цэгийн үйлчилгээгээр дамжуулан 67 иргэн хүргэж, ажил хайгч 25 иргэнийг ХЗЗБМНС-д бүртгэн баталгаажуулсан. 7 дугаар сард 11 иргэнийг түр болон байнгын ажлын байранд зуучилсан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад Эрдэнэ сумын 20 иргэнийг хамруулав.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн санд 21 иргэнийг ажил хайгчаар бүртгэж, 16 ажил олгогч байгууллага, 34 сул чөлөөтэй ажлын байр, 9 ажилд зуучлагдсан иргэн, 56 шинэ ажлын байрны мэдээллийн санд орууллаа.

ХХҮГ-ын даргын тушаалаар “Малжуулах” арга хэмжээнд Угтаалцайдам, Баян, Сэргэлэн, Баянхангай сумын 5 өрхөд 24000,0 мян төгрөгийн 523 бог малыг хүлээлгэн өгч 10 ажлын байрыг ХЗЗ-ийн мэдээллийн санд бүртгэсэн.

Санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 3 сумын 5 төсөл дэмжигдэж 17,9 сая төгрөгийн санхүүжилт олгоод байна.

Нийгмийн даатгалын үйлчилгээ: Аймгийн хэмжээнд 148 иргэд, даатгуулагчдад 91.3 сая төгрөгийн тэтгэмж олгосон.

Нийгмийн хамгааллын сайдын 2015 оны А/30 дугаар тушаалын хэрэгжилтийн хүрээнд Нийгмийн даатгалын сангаа солгох Тэтгэмжийн даатгалын сан болон Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгосон хөдөлмөрийн чадвар алдсаны, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн тогтоолт, олголтын эрх зүйн үндэслэл, анхан шатны баримтын бүрдэлд, төрийн болон хувийн хэвшлийн эмнэлгүүдээс олгосон эмнэлэгийн хуудасны үндэслэлд хяналт шалгалт хийлээ. Шалгалтаар ЭМТ-үүд эмнэлгийн хуудас бичихдээ хоног илүү бичиж тэтгэмжийн даатгалын сангаас 10 даатгуулагчид 4.3 сая төгрөг илүү олгосон зөрчлийг илрүүлсэн бөгөөд үүнд улсын байцаагчдын акт тогтоож шийдвэрлэсэн.

Заамар суманд нийгмийн салбарын Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулж Иргэд даатгуулагчдад зөвлөгөө мэдээлэл хүргэн, нийгмийн даатгалын дэвтэр баталгаажуулах, сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын ногдуулалт хийх, өртэй ААН-ийн төлөөлөлтэй уулзалт хийж, 74 сая төгрөгийн шимтгэлийн өрийг барагдуулан, цахим нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан нийт **102** иргэнд үйлчилгээ хүргэсэн.

Эрүүл мэндийн үйлчилгээ: “Нярайн сурфактант эмчилгээний зааврын хэрэгжилтийг сайжруулах нь” сэдэвт 3 өдрийн сургалтыг зохион байгуулж, нийт 75 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдыг хамруулсан.

НЭМҮТ-өөс “Халдварт бус өвчин, осол гэмтлийн эрсдэлт хүчин зүйлийн шалтгаан хамаарлыг тогтоох” улсын V судалгааны баг 13 суманд ажиллаж, мэдээлэл цуглуулсан.

Хүүхдийг эхийн сүүгээр хооллохыг дэмжих дэлхийн долоо хоногийг “Энхрий үрс эрүүл торниход Эцэг хүний үүрэг чухал” уриатай аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, иргэдэд мэдээлэл, сургалт сурталчилгаа хийж байна. Нярайн гэрийн эргэлт, аавуудын уулзалт өдөрлөг, ганцаарчилсан зөвлөгөө, ажлын байран дахь сургалт зэрэг хэлбэрээр нийт 435 иргэнд зөвлөгөө, зөвлөмж, мэдээлэл өгсөн. 2 төрлийн постер 114 ширхэгийг албан байгууллага, аж ахуй нэгжийн мэдээллийн самбарт байршуулсан.

“Тамхинаас гарах зөвлөгөө өгөх” ур чадварт сургах сургалтыг НЭМҮТ-тэй хамтран зохион байгуулж, нийт 28 эмч, НЭМА-ууд хамруулсан.

ЭМЯ, Глобал сангийн дэмжлэгтэйгээр “Бичил уул уурхай эрхлэгчдийн дунд сүрьеэ өвчний эрт илрүүлэг, үзлэг шинжилгээ”-г Заамар сум, Хайлааст багт зохион байгуулж, асуумж судалгаанд 620, цээжний рентген аппаратаар 610 хүнийг үзлэгт хамруулснаас уушгины эмгэг өөрчлөлттэй 259, шинэ сүрьеэ 1 тус тус илрүүлж, хавьтлын судалгаа хийгдсэн. Мөн 500 хүнийг ДОХ/БЗДХ-ын шинжилгээнд хамруулж шинээр 11 тэмбүү ирлүүлж 620 хүнд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө зөвлөмж, мэдээлэл хүргэлээ.

Зуунмод сумын 10 цэцэрлэгт хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээг Нэгдсэн эмнэлэг, Өрхийн эрүүл мэндийн төв, цэцэрлэгүүдтэй хамтран зохион байгуулж 1243 хүүхдийг хамруулсан.

Халдварт өвчний 14 голомтод тархвар зүйн тандалтын судалгаа хийж урьдчилан сэргийлэх болон голомтын халдваргүйтгэлийг хийлээ.

Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:

Төсвийн орлогын талаар: 2019 оны 07-р сарын байдлаар аймгийн төвлөрсөн төсвийн орлогын төлөвлөгөө 9951,4 сая төгрөг оруулахаас 10617,3 сая төгрөг оруулж, төсвийн орлогын төлөвлөгөө 665,9 сая төгрөг буюу 106,7 хувиар биелсэн.

Сумдын орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 125,8 хувь буюу 537,9 сая төгрөгөөр давж биелэв. Сумдын төсвийн орлого давж биелэхэд үйл ажиллагааны орлого 130,0 сая төгрөг, хадгаламжийн хүүгийн орлого 108.2 сая төгрөг, ҮХЭХ борлуулсаны албан татвар 21,4 сая төгрөг, хүү торгуулийн орлого 65,6 сая төгрөг, бусад орлого 137,1 сая төгрөгөөр тус тус давж биелэсэн нь нөлөөлжээ. Алтанбулаг, Архуст, Баян, Баян-Өнжүүл, Дэлгэрхаан, Өндөрширээт, Зуунмод зэрэг 7 сумд орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг тасалдуулжээ.

Аймгийн төвлөрсөн төсвийн орлогоос ҮХЭХ-ийн орлого, ус ашигласны төлбөрийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Аймгийн төвлөрсөн төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Архуст, Баян, Баянжаргалан, Борнуур, Сэргэлэн, Сүмбэр, Угтаал, Эрдэнэ зэрэг 8 сум тасалсан байна.

Төсвийн зарлага санхүүжилтийн талаар: Сумдад эхний 07 сарын байдлаар өссөн дүнгээр нийт 49.298.851,6 мянган төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

Салбараа авч үзвэл: Боловсрол,соёл, шинжлэх ухаан, спортын сайдын багцаас 20.228.430,6 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

-Ерөнхий боловсролын сургуулиудад 13.855.153,5 мянган төгрөг

-Хүүхдийн цэцэрлэгт 6.373.277,1 мянган төгрөг тус тус олгоод байна.

Эрүүл мэндийн сайдын багцаас 4.960.713,8 мянган төгрөгийг олгосон.Үүнд:

-Сумдын эрүүл мэндийн төвд 4.828.216,6 мянган төгрөг

-Өрхийн эмнэлэгт 132.497,2 мянган төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 324.730,2 мянган төгрөг, Хүүхэд гэр бүл, залуучуудын хөгжлийн газарт 269.662,8 мянган төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 23.515.314,2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

-Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 14.179.303,7 мянган төгрөг

-Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 7.612.644,6 мянган төгрөг

-ОНХСангуудад 1.723.365,9 мянган төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

Өр, авлагын талаар: 2019 оны 7-р сарын ХБГ-ээр сумд болон төсөвт байгууллагууд нийт 111.377,3 мянган төгрөгийн авлага, 411.084,2 мянган төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 95.665,2 мянган төгрөг буюу 23,3 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг, 120.894,7 мянган төгрөг буюу 29,4 хувь нь цалингийн өглөг, 53.739,3 мянган төгрөг буюу 13,1 хувь нь НДШимтгэлийн өр, 22.835,3 мянган төгрөг буюу 5,6 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, 36.706,3 мянган төгрөг

буюу 8,9 хувь эмийн зардлын өглөг, үлдсэн 81.243,4 мянган төгрөг буюу 19,7 хувийг бусад өр эзэлж байна.

Долоо. Хяналт-шинжилгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

Аймгийн Засаг даргын орлогчийн баталсан удирдамжийн дагуу 15 суманд “Хөрөнгө оруулалт- бүтээн байгуулалт”-ын урианы жилийн хүрээнд хийсэн ажил, Газар тариалангийн үйлдвэрлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт, Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилт, Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх хөтөлбөрийн хэрэгжилт, Хог хаягдлын менежментийг сайжруулах хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилт, “Хөгжлийн түүчээ- Төв аймаг”- 2024 хэтийн чиглэлийн хэрэгжилтэд явцын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Менежментийн тогтолцоо нэвтрүүлэх ажлын хүрээнд гарын авлага, дотоод аудит хийх журам, үл тохирлыг залруулах журам, сэргийлэх ажиллагааны журам, залруулах ажиллагааны журмуудыг боловсруулан батлуулж, хэлтсүүдэд хүргүүлэв.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар